



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 05 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 127/1423

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ХАЯНХЯРВАА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0006093

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.ЖАВХЛАН, Б.БАТТӨМӨР,
Д.ХАЯНХЯРВАА НАРААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1. Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний хэрэлжилтэд Засгийн газраас хэрхэн хяналт тавьж ажиллаж байгаа вэ?

Концессын гэрээний 8.3-т "Концесс эзэмшигч нь жилийн эцэст гэрээний хэрэгжилтийн талаар тайлан мэдээг гарган Эрх бүхий этгээдэд ирүүлэх үүрэгтэй" гэж заасны дагуу Үндэсний хөгжлийн газарт уг гэрээний хэрэгжилттэй холбоотой 2017 болон 2018 оны мэдээ тайланг концесс эзэмшигчээс ирүүлээд байна. Мөн гэрээний 8.1-т "Эрх бүхий этгээд нь холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан энэхүү гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно" гэж заасны дагуу 2018 оны 10 дугаар сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Үндэсний хөгжлийн газрын хамтарсан ажлын хэсэг байгуулан концессын гэрээний хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, ажилласан.

Асуулга 2. Гэрээний хэрэгжилтийн үр дүн, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг өгнө үү.

"Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээний хэрэгжилтийн үр дүн болон гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тус концессын гэрээнд заасан концессын зүйл тус бүрээр тайлагнаж байна. Үүнд:

- Гэрээний 2.1.1-т "Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилдээ 3,0 саяас доошгүй тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1,5 саяас доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр байгуулах" гэсэн концессын зүйлийн хүрээнд Төмөртолгойн ордод жилд 2 сая тн хүдэр боловсруулж 1,4 тн баяжмал үйлдвэрлэх хүчин чадал бүхий хуурай соронзон аргын баяжуулах үйлдвэрийг 2015 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад оруулж Улсын комисст хүлээлгэн өгсөн. Тус ордод жилд 3.5 сая хүдэр боловсруулж, 2.4 сая тн баяжмал үйлдвэрлэх хүчин чадал бүхий хуурай соронзон аргын баяжуулах үйлдвэрийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад оруулж Улсын комисст хүлээлгэн өгсөн. Төмөртэйн ордод жилд 1 сая тн хүдэр боловсруулж, 700,0 мян.тн 65% -ийн агууламжтай баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг мөн ашиглалтад оруулсан бөгөөд тус цехийн барилгыг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн.

- Гэрээний 2.1.2-т "Жилд 500,0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах" гэсэн концессын зүйлийн хүрээнд шууд ангижруулсан төмрийн үйлдвэр барих талбайн инженер геологийн судалгааг хийлгэж, тайланг хүлээн авсан бөгөөд ТЭЗҮ боловсруулах ажлыг Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Аж үйлдвэрийн яамны захиалгаар /одоогийн УУХҮЯам/ 2016 оны 04 дүгээр сард эхлүүлэн Канад улсын Хатч компаниар хийлгүүлж дуусах шатандаа орсон байна.

-Гэрээний 2.1.3-т "Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн хүчин чадлыг жилийн 300 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх (төмрийн хүдэр

боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах)" гэсэн концессын зүйлийн хүрээнд 25,000 тн/жил хүчин чадалтай ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэрийг 2016 онд, бэлдэц үйлдвэрлэх цех дэх 25 тн-ын багтаамжтай шанаган зуухны тоног төхөөрөмж, барилга байгууламжийг 2017 онд, бэлдэц үйлдвэрлэх цехийн 6/0.4 кв-ын 1600 кВА дэд станц, үйлдвэрийн 110/22/6.6/6 кв-ын Төмөрлөг дэд станцыг 110/22 кв-ын 6.3 МВА дэд станцаар өргөтгөсөн өргөтгөл, 22кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугамын барилгыг 2018 онд тус тус хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн. Мөн хаягдал төмрийг боловсруулах пресс хайчны тоног төхөөрөмжийн угсралт, барилга байгууламжийг 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Техникийн комисст хүлээлгэн өгөөд байна.

-Гэрээний 2.1.4-т "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) хүртэлх 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминалын хамт барих" гэсэн концессын зүйлийн хүрээнд төмөр замын барилгын ажлыг бүрэн хийж гүйцэтгэн Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2015 оны 12-р сарын 28-ны өдрийн 02/18/15 дугаар актаар байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016.02.01-ний өдрийн "Концессын зүйлийг төрийн өмчид шилжүүлэн авах тухай" 77 дугаар тогтоолоор Төрийн өмчит "Монголын төмөр зам" ХХК-ийн өмчид шилжүүлэн авсан.

-Гэрээний 2.1.5-д "Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих" гэсэн концессын зүйлийн хүрээнд "Сэлэнгэ аймгаар дайран өнгөрөх олон улсын авто замтай холбох хатуу хучилттай 95 км авто замын барилга" –ын эхний 25 км авто замыг байнгын ашиглалтад оруулахаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2016 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 07/07/16 дугаар актаар, Сэлэнгэ аймгийн нутагт баригдсан Дулаанхааны 4 замын уулзвараас Ерөө-Хүдэр сумын чиглэлийн 4-р ангиллын хатуу хучилттай авто замын 2-р хэсгийн 40км авто замыг ашиглалтад оруулахаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 07/10/17 дугаар актаар, Дулаанхааны 4 замын уулзвараас Ерөө-Хүдэр сум чиглэлийн 95 км хатуу хучилттай авто замын 3-р хэсгийн 30 км авто замыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 07/17/17 дугаар актаар дүгнэлт гаргаснаар нийт 95 км хатуу хучилттай авто замыг Улсын комисст бүрэн хүлээлгэн өгч, ашиглалтад оруулсан.

-Гэрээний 2.1.6-д "Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (50км), өргөтгөл, дэд станцын хамт барих" гэсэн концессын зүйлийн хүрээнд тус цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станцыг барьж дуусган Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн №11/2014 тоот актаар байнгын ашиглалтад оруулсан.

Асуулга 3. Гэрээ хэрэгжиж эхэлсэн өдрөөс хойш 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хэдийн хэмжээний хүдэр олборлож, гэрээний ямар зүйл заалт болон бусад зөвшөөрлийн хүрээнд хичнээн тонн төмрийн хүдрийг экспортоор гаргасан бэ?

Хүдэр олборлолтын хэмжээ 2014 онд 2178.9 мян.тонн, 2015 онд 18.8 мян.тонн, 2016 онд 539.4 мян.тонн, 2017 онд 2563.4 мян.тонн, 2018 онд 1566.9

мян.тонн, 2019 оны 3 дугаар сарын байдлаар 299.2 мян.тонн буюу нийтдээ 7166.6 мян.тонн байна.

Концессын гэрээний гуравдугаар бүлэгт концесс эзэмшигчийн концессын зүйлтэй холбоотой онцгой эрхийн харилцааг зохицуулсан бөгөөд гэрээний 3.4-т “Энэхүү гэрээний хугацаанд концесс эзэмшигч нь Тусгай зөвшөөрлүүдэд хамаарах орд газруудад олборлолт явуулах” ашиглах онцгой эрхийг дангаар эдэлнэ” гэж, 3.5-т “Төслийн хүрээнд бий болох Бүтээгдэхүүнийг бие даан захиран зарцуулах, үнэ ханшийг тогтоох, захиран зарцуулснаас бий болсон үр шимийг хүртэх эрхтэй” гэж, 6.22-т “Дотоодын зах зээлд борлуулаад илүү гарсан бүтээгдэхүүнийг экспортлох эрхтэй” гэсэн заалтуудыг үндэслэн 2014 онд 101.5 мян.тонн, 2015 онд 393.3 мян.тонн, 2016 онд 1056.3 мян.тонн, 2017 онд 749.6 мян.тонн, 2018 онд 1097.8 мян.тонн, 2019 оны 03 дугаар сарын байдлаар 477.3 мян.тонн буюу нийтдээ 3875.8 мян.тонн хүдрийн баяжмалыг экспортолсон байна.

Асуулга 4. Нийт экспортын орлогын зарцуулалт болон үндсэн төсөлдөө оруулсан хөрөнгө, мөн улс, орон нутгийн төсөвт ямар хэмжээний орлого оруулсан талаарх мэдээлэл өгнө үү.

Концесс эзэмшигчийн 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр ирүүлсэн тайлангаар уг төсөлд одоогийн байдлаар 630,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан бөгөөд үүнийг дэлгэрэнгүй үзүүлбэл дараах байдалтай байна.

№	Дэд төслийн нэр	Төслийн зорилго	Хүчин чадал	Хөрөнгө оруулалт /сая.төг/
1	Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /50км/, өргөтгөл, дэд станц бүхий төсөл	Төмөртэйн уурхайг цахилгаан эрчим хүчээр хангах	110кВт, 50км	12,576.20
2	Төмөртэйн ордоос Хандгайт өртөө /Сэлэнгэ аймгийн Хүдэр сум/ чиглэлийн 1520мм царигтай төмөр зам, өртөө, ачиж буулгах терминал бүхий төсөл	Төмөртэйн уурхайн бүтээгдэхүүний тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өртөг бууруулах	жилд 7-8 сая.тн ачаа тээвэрлэх	212,788.30
3	Сэлэнгэ аймгаар дамжин өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км авто замын төсөл	Уурхайн баяжмал тээвэрлэх шаардлагагүй гэж үзэн хүнд даацын авто замын төсөл байсныг хатуу хучилттай авто зам болгон төслийг хэрэгжүүлсэн	95 км хатуу хучилттай авто зам	95,272.20

4	Сэлэнгэ аймгийн Хүдэр сум дахь Төмөртэйн уурхайн олборлох хүчин чадлыг бий болгох тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын төсөл	Уурхайн хүдэр олборлох хүчин чадлыг бий болгох	Жилд 3-4.5 сая.тн хүдэр олборлох	81,200.70
5	Төмөртэйн уурхайд 750тн/ц хүдэр боловсруулах хүчин чадал бүхий АНУ-ын TRIO, EREIZ брэндийн хуурай соронзон аргын баяжуулах үйлдвэр	Төмрийн хүдрийг баяжуулж төмрийн агуулгыг нэмэгдүүлэх	Цагт 750тн/ц боловсруулах	10,850.10
6	Дархан-Уул аймгийн Хонгор суманд орших Төмөртолгойн уурхайн олборлох хүчин чадлыг бий болгох тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын төсөл	Төмөртолгойн уурхайн хүдэр олборлох хүчин чадлыг бий болгох	Жилд 3 сая.тн хүдэр олборлох	27,121.40
7	Төмөртолгойн уурхайн 150тн/цаг хүдэр боловсруулах хүчин чадал бүхий хуурай аргын соронзон баяжуулах үйлдвэр	Төмрийн хүдрийг баяжуулж төмрийн агуулгыг нэмэгдүүлэх	Цагт 150тн/ц боловсруулах	2,332.80
8	Төмөртолгой уурхай жилд цагт 250тн/цаг хүдэр боловсруулах хүчин чадал бүхий хуурай аргын соронзон баяжуулах үйлдвэр	Төмрийн хүдрийг баяжуулж төмрийн агуулгыг нэмэгдүүлэх	Цагт 250тн/ц боловсруулах	4,147.20
9	Төмөртолгой уурхай жилд цагт 500тн/цаг хүдэр боловсруулах хүчин чадал бүхий хуурай аргын соронзон баяжуулах үйлдвэр	Төмрийн хүдрийг баяжуулж төмрийн агуулгыг нэмэгдүүлэх	Цагт 500тн/ц боловсруулах	6,160.50
10	Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд уурхайн бүтээгдэхүүн ачиж тээвэрлэх зориулалт бүхий терминал барьж байгуулсан	Төмөртолгойн уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх	Жилд 1 сая.тн бүтээгдэхүүн тээвэрлэх	3,771.20
11	Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд нойтон баяжуулах үйлдвэрийг жилийн 1 сая.тн боловсруулах хүчин чадалтайгаар Гангийн үйлдвэрийн дэргэд барьж байгуулсан.	ШАТ-ийн үйлдвэр баригдахад түүхий эд нийлүүлэх зорилготой үйлдвэр	Жилд 1сая.тн хүдэр боловсруулах	11,611.20
12	Төмөртэйн уурхайн ажилчдын амрах, чөлөөт цаг өнгөрүүлэх, хооллох болон бусад ариун цэврийн, анхны тусламжийн хэсэг бүхий кэмп	Уурхайн ажилчдын байр	400 хүний багтаамж бүхий	1,613.40

13	Төмөртэйн уурхайн дэргэд уул уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх зориулалт бүхий засварын төв, оффисын байрын хамт барих төсөл	Техникийн бэлэн байдлыг хангах засвар үйлчилгээний төвтэй болсон	22x60 бүхий талбайтай	2,237.70
14	Гангийн үйлдвэрт шинээр шанаган зуух суурилуулах төсөл	Ган бэлдэц бүтээгдэхүүний орц найрлага тохируулах, чанар сайжруулах	25тн багтаамжтай	4,103.30
15	Ган бөмбөлөг давтах аргаар үйлдвэрлэх евро стандартын үйлдвэр байгуулах	Ган бүтээгдэхүүний төрөл нэмэгдүүлэх, импортыг орлох	100-140 мм голчтой, жилд 25000 тн	17,689.60
16	Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн үндсэн дизайн, инженерингийн зураг төсөл боловсруулах	Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн дизайн зураг	2017 оны 1-р сард бэлэн болсон	3,168.20
17	Хаягдал төмөр пресслэн хайчлаж боловсруулах тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт	Хаягдал төмөр боловсруулах бүтээмж нэмэгдүүлэх, чанар сайжрах		776.20
18	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК-ийн захиргааны болон үйлдвэр, цехийн дулааныг төвийн дулааны шугамд холбох төсөл	Нүүрсний хэрэглээ багассан, дулаан нэмэгдсэн, утаа буурсан	2 км дулааны шугам	1,731.60
19	Тасралтгүй цутгах машинд цахилгаан соронзон хуйлруулагч шинээр суурилуулах, хэлбэлзүүлэгч ширээ шинэчлэх төсөл	Бэлдэцийн чанар сайжрах, найдвартай ажиллагааг хангах	4 ширхэг	2,594.60
20	Судалгаа техник эдийн засгийн үндэслэл	Уурхай олборлох байгаль орчин		1,649.20
21	Концессын төлбөрт Улсын төсөвт төвлөрүүлсэн	Төсөвт ДТҮ-ээс өгсөн хамгийн өндөр ноогдол ашгийг 30 жилээр тооцож төлөх		31,900.00
22	Төслийн санхүүжилтийн зардалд зарцуулсан			95,546.10
	Нийт дүн			630,841.70

Мөн тус тайлангаар концесс эзэмшигч нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Үл хөдлөх хөрөнгийн татвар, Газрын төлбөр, Хувь хүний орлогын татвар, Нийгмийн даатгалын даатгалын шимтгэл, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар зэрэгт 2014-2018 оны хооронд

нийт 55,1 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд үүнийг дэлгэрэнгүй байдлаар үзүүлбэл дараах байдалтай байна.

Улс, орон нутгийн төсөвт төлсөн төлбөр

№	Төрөл	Хэмжих нэгж	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	Нийт дүн
1	АМНАТ	сая.төг	1,241.4	3,653.4	3,277.3	4,844.4	6,662.0	19,678.4
2	НӨАТ	сая.төг	950.0	1,856.3	2,116.6	1,415.7	2,970.6	9,309.1
3	ҮХХТ	сая.төг	106.3	101.2	115.4	104.3	104.9	532.1
4	Газрын төлбөр	сая.төг	3.9	74.9	52.8	44.4	55.2	231.1
5	ХХОАТ	сая.төг	2,071.5	1,117.8	837.4	1,346.9	1,366.1	6,739.7
6	НДШ	сая.төг	5,242.8	2,990.9	2,545.4	3,563.5	4,165.4	18,508.1
7	АТБӨЯХТ	сая.төг	58.5	46.0	24.0	17.5	23.7	169.7
Нийт дүн			9,674.3	9,840.5	8,969.0	11,336.7	15,347.9	55,168.2

Асуулга 5. Энэ гэрээг цаашид хэрхэх талаар Засгийн газрын байр суурь.

Концессын гэрээний хэрэгжилтийг дүгнэж, концесс эзэмшигчээс ирүүлсэн тайлангийн бодит гүйцэтгэл, хийгдсэн ажлуудын тоо мэдээлэл, чанар байдал, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг нягталж цаашид авах арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Эрчим хүчний яам, Үндэсний хөгжлийн газар болон холбогдох бусад талуудыг оролцуулсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байгаа болно. Тус ажлын хэсгийн санал дүгнэлтэд үндэслэн уг төсөл дээр цаашид авах арга хэмжээг шийдвэрлэхээр төлөвлөж байна.

-----oOo-----